

ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ

/шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилго

1.1.Энэ хуулийн зорилго нь төрийн хяналт шалгалт, түүнийг хэрэгжүүлэх нийтлэг үндэслэл, журам, хяналт шалгалтын арга, улсын байцаагчийн авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, энэхүү үйл ажиллагаанд хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад оршино.

2 дугаар зүйл. Төрийн хяналт шалгалтын тухай хууль тогтоомж

2.1.Төрийн хяналт шалгалтын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Захиргааны ерөнхий хууль, салбарын бусад хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Төрийн хяналт шалгалтын тогтолцоо, хүрээ

3.1.Төрийн хяналт шалгалт нь хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдэл, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын хяналт шалгалт, шүүх эрх мэдлийн хяналтаас бүрдэнэ.

3.2.Энэ хууль дараах харилцаанд үйлчлэхгүй:

3.2.1.Улсын Их Хурлын хяналт шалгалт;

3.2.2.гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд доод шатны болон харьяа байгууллага, албан газрын үйл ажиллагаанд тавих хяналт;

3.2.3.төрийн аудитын үйл ажиллагаа;

3.2.4.нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын хяналт шалгалт;

3.2.5.Захиргааны ерөнхий хуулийн 3 дугаар зүйлд заасан харилцаа.

3.3.Энэ хуулийн 3.2-т зааснаас бусад гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас хийх хяналт шалгалтын харилцааг тухайлсан хуулиар өөрөөр зохицуулаагүй бол энэ хуулийг дагаж мөрдөнө.

4 дүгээр зүйл. Хяналт шалгалтын зарчим

4.1.Хяналт шалгалтыг хэрэгжүүлэхэд Захиргааны ерөнхий хуулийн 4.2-т заасан зарчмаас гадна дараах тусгай зарчмыг баримтална:

4.1.1.эрсдэлд суурилах;

4.1.2.шалгуулагчийн хандлагыг харгалзах;

4.1.3.алсын хараатай байх;

4.1.4.нэгдмэл тогтолцоотой байх;

4.1.5.хараат бус, бие даасан байх;

- 4.1.6.мэдээллийн нэгдсэн сан ашиглах;
- 4.1.7.мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;
- 4.1.8.мэргэжлийн ур чадварыг дээдлэх;
- 4.1.9.хяналт шалгалт хууль ёсны байх.

4.2.Энэ хуулийн 4.1-д заасан хяналт шалгалтын зарчмыг дор дурдсан агуулгаар ойлгоно:

4.2.1.“эрсдэлд суурилах” гэж хяналт шалгалтын хамрах хүрээ болон хяналт шалгалтын объект, бараа бүтээгдэхүүн бүрээр эрсдэлийн үнэлгээ хийж, тэдгээрийг эрсдэлийн түвшинээр нь эрэмбэлсэний үндсэн дээр хяналт шалгалтын ажлыг оновчтой төлөвлөхийг;

4.2.2.“шалгуулагч этгээдийн хандлагыг харгалзах” гэж шалгуулагч этгээд нь алдаа, дутагдал давтан гаргасан, эсхүл хууль тогтоомжийн шаардлагыг хэрхэн биелүүлж байгаа идэвх, санаачилгыг харгалзан хяналт шалгалтын давтамж, шалгалтын дагуу авах арга хэмжээг тохируулан хэрэглэхийг;

4.2.3.“алсын хараатай байх” гэж төрийн хяналтын үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх, нөөц бололцоог хамгийн үр өгөөжтэй чиглэлд төвлөрүүлэх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүндрэл учруулахгүй байх, ил тод байдлыг сайжруулах, шуурхай хариу арга хэмжээ авдаг байх зэрэг ерөнхий болон нарийвчилсан зорилго, зорилтыг дэвшүүлэн, шинэтгэлийг тасралтгүй, тууштай хэрэгжүүлэхийг;

4.2.4.“нэгдмэл тогтолцоотой байх” гэж төрийн хяналтын чиглэлийг өөр өөр байгууллага, албан тушаалтанд хариуцуулж хяналт, шалгалтын давхардал, хийдэл үүсгэхээс зайлсхийж, нэгдсэн бодлого, стандарт, бүхий нэг тогтолцоонд оруулахыг;

4.2.5.“хараат бус, бие даасан байх” гэж хяналтыг хөндлөнгийн нөлөөллөөс хараат бус, төрийн хяналт шалгалтын байгууллага, улсын байцаагч бие даасан шийдвэр гаргах, шалгуулагчийн нөлөөнд автахаас зайлсхийх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхыг;

4.2.6.“мэдээллийн нэгдсэн сан ашиглах” гэж хяналт шалгалтын үр дүнг сайжруулах, уялдуулан зохицуулах зорилгоор хяналт шалгалтын статистик мэдээлэл, удирдлагын төвлөрсөн нэгдсэн систем байгуулан, ашиглахыг;

4.2.7.“мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх” гэж шалгуулагч этгээдэд хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт, стандартын шаардлагыг биелүүлэхэд тулгардаг хүндрэл бэрхшээлийг багасгахад нь мэргэжлийн туслалцаа үзүүлэхийг;

4.2.8.“мэргэжлийн ур чадварыг дээдлэх” гэж хяналт шалгалтыг мэргэжлийн өндөр түвшинд хэрэгжүүлэх үүднээс нарийн мэргэжлийн мэдлэг болон хяналт шалгалт явуулах ерөнхий ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг;

4.2.9.“хяналт шалгалт хууль ёсны байх” гэж хяналт шалгалтыг гагцхүү хуулиар эрх олгогдсон хяналт шалгалтын байгууллага, улсын байцаагч хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актаар тогтоосон үндэслэл, журмын дагуу хэрэгжүүлэх.

5 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

5.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

5.1.1.“хяналт шалгалт” гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт, стандарт, техникийн зохицуулалтын шаардлагад нийцэж байгаа эсэхийг тогтоож, түүнд нийцүүлэхэд чиглэсэн энэ хуулийн дагуу мэргэжлийн хяналтын байгууллага болон хуулиар хяналт шалгалт хийхээр тусгайлан эрх олгогдсон төрийн захиргааны бусад байгууллагын хуулийн хэрэгжилтэд хяналт тавих цогц арга хэмжээг;

5.1.2.“шалгалт” гэж хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, объект, түүнчлэн экспорт, импортын болон үйлдвэрлэж, борлуулж байгаа бараа, бүтээгдэхүүн, үзүүлж байгаа үйлчилгээ хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг газар дээр нь биечлэн үзэж шалгах, болзошгүй аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахад чиглэсэн хуулиар эрх олгогдсон хяналт шалгалтын байгууллага, улсын байцаагчийн цогц арга хэмжээг;

5.1.3.“хяналт” гэж Засгийн газар, яам, агентлаг, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргаас доод шатны байгууллага, албан тушаалтан, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйлдэл, эс үйлдэхүй хуульд нийцэж буй эсэхийг дүгнэхэд чиглэсэн үйл ажиллагааг;

5.1.4.“эрсдэл” гэж хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, үйлдвэрлэл, ажил, үйлчилгээний явцад хууль, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт, стандарт зөрчигдсөнөөс хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчны аюулгүй байдалд учирч болзошгүй сөрөг үр дагавар, түүний үүсэх магадлалыг;

5.1.5.“эрсдэлийг үнэлэх” гэж сөрөг үр дагавар үүсэх магадлал болон учирч болзошгүй хохирлын хэмжээгээр тодорхойлогдох тухайн объект, үйл ажиллагаа, асуудлын шинж чанарыг;

5.1.6.“хяналт шалгалтын байгууллага” гэж хяналт шалгалт хийх эрх бүхий мэргэжлийн хяналтын байгууллага болон хуулиар тусгайлан эрх олгогдсоны дагуу хяналт шалгалт хийх эрх бүхий төрийн захиргааны бусад байгууллага, тэдгээрийн улсын байцаагчийг;

5.1.7.“хяналтын хуудас” гэж хяналт шалгалтын болон хүн, хуулийн этгээдийн талаарх ерөнхий мэдээлэл, хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актын хэрэгжилтийн байдлыг тогтооход чиглэгдсэн асуултууд, хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт зөрчигдсөнөөс гарч болох эрсдэлийг үнэлж тодорхойлох өгөгдөл зэргээс бүрдсэн үнэлгээний хуудсыг;

5.1.8.“шалгуулагч этгээд” гэж шалгалтад хамрагдаж буй хүн, хуулийн этгээд, төрийн байгууллага, албан тушаалтныг;

5.1.9.“мэргэжлийн хяналтын байгууллага” гэж мэргэжлийн хяналтын төв байгууллага, аймаг, нийслэл, хил, гүний мэргэжлийн хяналтын газар, дүүргийн мэргэжлийн хяналтын газар, сумын мэргэжлийн хяналтын тасаг, мэргэжлийн хяналтын улсын байцаагчийг;

5.1.10."орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллага" гэж аймаг, нийслэл, хил, гүний мэргэжлийн хяналтын газар, дүүргийн мэргэжлийн хяналтын хэлтэс, сумын мэргэжлийн хяналтын тасгийг;

6 дугаар зүйл. Төрийн хяналт шалгалтын зорилго

6.1.Төрийн хяналт шалгалтын зорилго нь хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актын биелэлтийг хангуулахаар хуульд заасан үндэслэл, журмын дагуу хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, арилгуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх зэргээр болзошгүй аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд оршино.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Нэгдүгээр дэд бүлэг Хяналт шалгалтын төрөл, хэлбэр

7 дугаар зүйл. Хяналт шалгалтын төрөл

7.1.Хяналт шалгалт нь төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус гэсэн төрөлтэй байна.

7.2.Зорчигч, бараа, тээврийн хэрэгслийг хилийн боомт, гүний гаалийн хяналтын бүсээр нэвтрүүлэх үеийн хяналт шалгалтад энэ хуулийн 7.1 дэх хэсэг хамаарахгүй.

8 дугаар зүйл. Төлөвлөгөөт хяналт шалгалт

8.1.Хяналт шалгалтын байгууллага тухайн жилд хэрэгжүүлэх төлөвлөгөөт хяналт шалгалтын төлөвлөгөөг өмнөх оны 12 дугаар сарын 25-ний өдрийн дотор баталж, өөрийн цахим хуудсаар нийтэд мэдээлнэ.

9 дүгээр зүйл. Төлөвлөгөөт бус хяналт шалгалт

9.1.Хяналт шалгалтын байгууллага төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг дараах үндэслэлээр хэрэгжүүлнэ:

9.1.1.өөрийн санаачилгаар;

9.1.2.иргэн, аж ахуй нэгж, байгууллагын хүсэлт, өргөдөл, гомдлоор;

9.1.3.хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр иргэд, олон нийтийн анхааралд байгаа асуудлыг үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд;

9.1.4.дээд шатны байгууллага, албан тушаалтан, эсхүл эрх бүхий этгээдээс өгсөн үүрэг, даалгавраар;

9.1.5.хуульд заасан бусад үндэслэлээр.

9.2.Хяналт шалгалтын байгууллага энэ хуулийн 9.1.2-т заасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлт, өргөдөл, гомдлын дагуу хяналт шалгалт хэрэгжүүлэх эсэхийг ажлын 5 өдрийн дотор шийдвэрлэнэ.

10 дугаар зүйл. Хяналт шалгалтын хэлбэр

10.1.Хяналт шалгалтыг тандалт судалгаа, хяналт шинжилгээ, зөвлөн туслах үйлчилгээ, шалгалт гэсэн хэлбэрээр хэрэгжүүлнэ.

11 дүгээр зүйл. Тандалт судалгаа

11.1.Хяналт шалгалтын байгууллага хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, объект, бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээнээс хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчны аюулгүй байдалд учирч буй хор хөнөөлийг хянах, бууруулах зорилгоор тандалт судалгаа хийнэ.

12 дугаар зүйл. Хяналт шинжилгээ

12.1.Хяналт шалгалтын байгууллага хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, объект, бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээнээс хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчны аюулгүй байдалд хор хөнөөл учруулж болзошгүй хүчин зүйл байгаа эсэх, түүний шалтгааныг судлан тодорхойлох зорилгоор хяналт шинжилгээ хийнэ.

12.2.Хяналт шинжилгээг тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.

12.3.Хяналт шалгалтын байгууллага хяналт шинжилгээгээр илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар холбогдох этгээдэд албан шаардлага, зөвлөмж өгч болно.

13 дугаар зүйл. Зөвлөн туслах үйлчилгээ

13.1.Хяналт шалгалтын байгууллага эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах зорилгоор хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, объект, бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг хяналтын хуудсаар үнэлэн зөвлөгөө өгөх, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх замаар зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ.

13.2.Зөвлөн туслах үйлчилгээг тодорхой асуудлаар нийтлэг зөвлөмж гаргах, сургалт зохион байгуулах, нөхцөл байдалтай газар дээр нь танилцан зөвлөгөө, чиглэл өгөх хэлбэрээр зохион байгуулна.

13.3.Хяналт шалгалтын байгууллага иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтээр дараах тохиолдолд нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж болно:

13.3.1.үйл ажиллагаагаа эхлүүлэх, шинэчлэх, өргөтгөх;

13.3.2.хууль, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт, техникийн зохицуулалт өөрчлөгдсөн.

13.4.Зөвлөн туслах үйлчилгээг тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хувийн эрх зүйн хуулийн этгээдтэй хамтран хэрэгжүүлж болно.

13.4.Зөвлөн туслах үйлчилгээний хүрээнд илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар холбогдох этгээдэд зөвлөмж өгч болно.

14 дүгээр зүйл. Шалгалт

14.1.Хяналт шалгалтын байгууллага хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, объект, түүнчлэн экспорт, импортын болон үйлдвэрлэж, борлуулж байгаа бараа, бүтээгдэхүүн, үзүүлж байгаа үйлчилгээ хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг газар дээр нь биечлэн үзэж шалгах, болзошгүй аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах зорилгоор шалгалт хийнэ.

14.2.Шалгалтыг хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчны аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэл, аюул, хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор тодорхой асуудлын хүрээнд хэрэгжүүлж болно.

14.3.Тандалт судалгаа, хяналт шинжилгээ, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх явцад хүний амь нас, эрүүл мэнд, нийгмийн болон орчны аюулгүй байдалд хор хохирол учруулсан, учруулж болзошгүй бодит нөхцөл байдалд илэрсэн тохиолдолд шалгалт хийж болно.

14.4.Шалгалтыг гагцхүү хяналт шалгалтын байгууллагын улсын байцаагч эсхүл мэргэжлийн хяналтын улсын ерөнхий байцаагчаас улсын байцаагчийн эрх олгогдсон этгээд хэрэгжүүлнэ.

Хоёрдугаар дэд бүлэг Хяналт шалгалтын арга

15 дугаар зүйл. Хяналт шалгалтын арга

15.1.Хяналт шалгалтыг дараах нийтлэг аргаар хэрэгжүүлнэ:

- 15.1.1.баримт бичиг, мэдээлэлтэй танилцах;
- 15.1.2.тайлбар авах;
- 15.1.3.үзлэг хийх;
- 15.1.4.туршилт, хэмжилт, магадлал хийх;
- 15.1.5.дээж авч шинжилгээнд хамруулах;
- 15.1.6.хуульд заасан бусад арга.

16 дугаар зүйл. Баримт бичиг, мэдээлэлтэй танилцах

16.1.Улсын байцаагч бодит нөхцөл, байдлыг тогтооход хамааралтай, ач холбогдол бүхий баримт бичиг, мэдээллийг шалгуулагч этгээд болон холбогдох бусад этгээдээс үнэ төлбөргүйгээр гаргуулан авах, танилцах эрхтэй.

16.2.Улсын байцаагч шаардлагатай тохиолдолд баримт бичиг, мэдээллийг акт үйлдэн хүлээн авч, шалгалтын дүн гарсны дараа тухайн этгээдэд буцааж өгнө. Баримт бичгийг шалгалтын хувийн хэрэгт хавсаргахаар хуулбарлан авч болно.

17 дугаар зүйл. Тайлбар авах

17.1.Улсын байцаагч бодит нөхцөл, байдлыг тогтоох зорилгоор шалгуулагч этгээд болон бусад холбогдох этгээдээс тайлбар авах эрхтэй.

17.2.Тайлбарыг биечлэн эсхүл бичгээр авч болно. Тайлбарыг биечлэн авах тохиолдолд тодорхой асуулт тавьж, хариулт авах хэлбэрээр гүйцэтгэнэ.

18 дугаар зүйл. Үзлэг хийх

18.1.Улсын байцаагч ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, бараа, бүтээгдэхүүн, барилга, байгууламж, техник, тоног төхөөрөмж зохих шаардлагад нийцэж байгаа эсэхийг тогтоох зорилгоор шалгуулагч этгээдийн үйл ажиллагаа явуулдаг нутаг дэвсгэр, газар, барилга байгууламж, албан газар, тоног төхөөрөмж, бусад объект, тээврийн хэрэгсэл, ачаа, бараа, эд зүйлд үзлэг хийх эрхтэй.

18.2.Үзлэгийг шалгуулагч этгээд, түүний төлөөллийг байлцуулан хийнэ. Шалгуулагч этгээд, түүний төлөөлөл ирээгүй тохиолдолд улсын байцаагч үзлэг хийх ажиллагаанд хөндлөнгийн гэрчийг байлцуулах, эсхүл үзлэгийн ажиллагааг гэрэл зураг, дуу, дүрсний бичлэгээр бэхжүүлэх арга хэмжээ авна.

19 дүгээр зүйл. Туршилт, хэмжилт, магадлал хийх

19.1.Улсын байцаагч барилга байгууламж, ажлын байр, бодис, бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, тоног төхөөрөмж, даралтад сав, шугам хоолойны чанар аюулгүй байдал нь зохих шаардлагыг хангаж байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор туршилт, хэмжилт, магадлал хийх эрхтэй.

19.2.Туршилт, хэмжилт, магадлал хийхэд хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд хохирол учруулах арга, технологи ашиглахыг хориглоно.

19.3.Туршилт, хэмжилт, магадлал хийхэд энэ хуулийн 18.2-т заасан журам нэгэн адил үйлчилнэ.

20 дугаар зүйл. Дээж авч шинжилгээнд хамруулах

20.1.Улсын байцаагч агаар, ус, хөрс, бодис, бараа, бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, эд зүйлс нь зохих шаардлагад нийцэж байгаа эсэхийг тогтоох зорилгоор тэдгээрээс дээж авч итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд хамруулах эрхтэй.

20.2.Улсын байцаагч дээж авахдаа дараах ажиллагааг гүйцэтгэнэ:

20.2.1.Дээж авсан тухай акт үйлдэх ба актад дараах зүйлийг тусгана:

20.2.2.а. акт үйлдсэн газар, он, сар, өдөр, цаг, минут;

20.2.2.б.шалгуулагч этгээдийн нэр, хаяг;

20.2.2.в.дээж авахад байлцсан шалгуулагч этгээд, эсхүл түүнийг төлөөлсөн этгээдийн нэр, албан тушаал;

20.2.2.г.дээж авсан улсын байцаагчийн нэр, албан тушаал;

20.2.2.д.дээж авах үндэслэл, шаардлага;

20.2.2.е.бараа, бүтээгдэхүүнээс дээж авах тохиолдолд импортлосон улс болон үйлдвэрлэгчийн нэр;

20.2.2.ё.дээж авсан хугацаа, бараа, бүтээгдэхүүний нэр, төрөл, савлалт, цувралын дугаар, үйлдвэрлэсэн болон хадгалалтын дуусах хугацаа, нийт импортлосон болон дээжийн хэмжээ;

20.2.2.Энэ хуулийн 20.2.1-д заасан актыг гурван хувь үйлдэх бөгөөд шалгуулагч этгээд болон итгэмжлэгдсэн лабораторид тус тус нэг хувийг өгч, үлдэх хувийг шалгалтын хувийн хэрэгт хавсаргана.

20.2.3.дээжинд хийсэн шинжилгээний үр дүнг шалгуулагч этгээдэд нэн даруй мэдэгдэх;

20.2.4.шалгуулагч этгээдийн хүсэлтээр хоёр дахь дээжийг авч шинжилгээнд хамруулж болно.

20.3.Шалгуулагч этгээд хоёр дахь дээжийг шинжилгээнд хамруулах хүсэлт гаргаагүй бол эхний шинжилгээний үр дүнг хүлээн зөвшөөрсөнд тооцно. Эхний дээж болон хоёр дахь дээжинд хийсэн шинжилгээний үр дүн зөрүүтэй гарсан бол хоёр дахь дээжинд хийсэн шинжилгээний үр дүнг эцсийн гэж үзнэ.

20.4.Улсын байцаагч дээжийн бүрэн бүтэн байдал, ариун чанар, хадгалалт болон тээвэрлэлтийн горимыг хангах үүрэгтэй.

20.5.Дээж авснаар шалгуулагч этгээдийн үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээний хэвийн үйл ажиллагаа алдагдах тохиолдолд дээжийг шинжилгээнд хамруулсны дараа шалгуулагч этгээдэд буцаан өгнө.

20.6.Шинжилгээнд хамруулах дээжийн хэмжээ, дээжийг авах, хадгалах, тээвэрлэх, буцаан өгөх, лабораторид дээж хүлээн авах журмыг мэргэжлийн хяналтын төв байгууллагын дарга, шинжилгээний үнийг тогтоох, төлүүлэхтэй холбоотой журмыг мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

Гуравдугаар дэд бүлэг Шалгалт хийх

21 дүгээр зүйл. Шалгалт хийх журам

21.1.Зорчигч, бараа, тээврийн хэрэгслийг хилийн боомт, гүний гаалийн хяналтын бүсээр нэвтрүүлэх үеийн шалгалт болон хуульд өөрөөр зааснаас бусад шалгалтыг эрх бүхий этгээдийн баталсан удирдамжийн дагуу хэрэгжүүлнэ.

21.2.Шалгалтын удирдамжид дараах зүйлийг тусгана:

- 21.2.1.он, сар, өдөр, удирдамжийн нэгдсэн дугаар;
- 21.2.2.шалгалтын зорилго, үндэслэл;
- 21.2.3.шалгалтын хамрах хүрээ;
- 21.2.4.шалгуулагч этгээд, объектын нэр;
- 21.2.5.шалгалтын бүрэлдэхүүн, ажлын хэсгийн ахлагч;
- 21.2.6.шалгалт хийх хугацаа.

21.3.Улсын байцаагч шалгалт эхлэхээс өмнө шалгуулагч этгээдэд шалгалтын бүрэлдэхүүнийг танилцуулж, албаны үнэмлэхээ үзүүлж, дараах мэдээллийг өгнө:

21.3.1.шалгалтын удирдамжийг танилцуулж, нэг хувийг шалгуулагч этгээдэд өгөх;

21.3.2.улсын байцаагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, эсэргүүцсэн, шалгалтаас зайлсхийсэн тохиолдолд албадлага хэрэглэх, хуульд заасан хариуцлага хүлээлгэхийг сануулах.

21.4.Улсын байцаагч шалгалтыг гагцхүү шалгалтын удирдамжид заасан хамрах хүрээнд хийнэ.

21.5.Шалгалт хийхэд шалгуулагч этгээд, түүний төлөөллийг байлцуулах бөгөөд холбогдох этгээд байхгүй нь шалгалтыг хойшлуулах үндэслэл болохгүй.

21.6.Улсын байцаагч шалгалт хийх хугацаандаа шаардлагатай тохиолдолд байрлан ажиллах орон байр, техник хэрэгслийг шалгуулагч этгээдээс гаргуулж болно.

21.7.Улсын байцаагч шалгалт хийх явцдаа холбогдох хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт, стандартыг танин мэдүүлэх, шалгуулагч этгээдэд хяналтын хуудасны үнэлгээ, эрсдэлийн ангиллыг танилцуулж, эрсдэлийг бууруулах талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.

21.8.Улсын байцаагч шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, залруулах, түүний шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээг энэ хууль болон холбогдох бусад хуульд заасны дагуу авч хэрэгжүүлнэ.

21.9.Шалгалт хийхэд дараах зүйлийг хориглоно:

21.9.1.хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж шалгалт хийх;

21.9.2.шалгалтыг урьдчилсан дүгнэлт гаргаж, түүнийгээ батлах замаар хэрэгжүүлэх;

21.9.3.шалгуулагч этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулах хууль бус аргыг хэрэглэх;

21.9.4.шалгалтыг улсын байцаагчийн эрхгүй этгээд хийх;

21.9.5.шалгалтын дүн эцэслэн гараагүй байхад хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд харш аливаа баримт бичиг, мэдээллийг олон нийтэд тараах;

21.9.6.хуульд заасан бусад.

22 дугаар зүйл. Шалгалтын тэмдэглэл хөтлөх

22.1.Улсын байцаагч шалгалтын явцад тэмдэглэл хөтлөх бөгөөд тэмдэглэлд дараах мэдээллийг тусгана:

22.1.1.шалгалтын явц болон шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал;

22.1.2.улсын байцаагчийн санал, дүгнэлт, авсан арга хэмжээ;

22.1.3.шалгуулагч этгээдийн санал, хүсэлт.

22.2.Улсын байцаагч шалгалтын тэмдэглэлийн хувийг шалгуулагч этгээдэд өгнө. Шалгуулагч этгээд тэмдэглэлтэй танилцсан тухай гарын үсэг зурж

баталгаажуулах бөгөөд хэрэв гарын үсэг зурахаас татгалзсан бол улсын байцаагч энэ тухай тэмдэглэлд тусгана.

22.3.Шалгалтын явцад хийсэн дуу, дүрсний, бичлэг, гэрэл зургийг шалгалтын тэмдэглэлд хавсаргана.

22.4.Энэ зүйл нь зорчигч, бараа, тээврийн хэрэгслийг хилийн боомт, гүний гаалийн хяналтын бүсээр нэвтрүүлэх үеийн хяналт шалгалтад хамаарахгүй.

23 дугаар зүйл. Шалгалт хийх хугацаа

23.1.Хуульд өөрөөр заагаагүй бол тухайн шалгалтын үргэлжлэх хугацаа ажлын 15 өдөр хүртэл байх бөгөөд үүнд шалгалтын дүн гаргах хугацаа хамаарахгүй.

23.2.Нөхцөл байдлыг тодруулан шалгах шаардлагатай гэж үзвэл удирдамжийг баталсан албан тушаалтан шалгалт хийх хугацааг 30 хүртэл хоногоор сунгаж болно.

24 дүгээр зүйл. Шалгалтын дүнг гаргах

24.1.Улсын байцаагч шалгалт дуусснаас хойш ажлын 5 өдрийн дотор шалгалтын танилцуулга бичиж, дээд шатны улсын байцаагч болон удирдах албан тушаалтанд танилцуулна.

24.2.Шалгалт дуусахаас өмнө шалгалтын явцад авсан дээжинд хийсэн шинжилгээний хариу гараагүй тохиолдолд шалгалтын дүн гаргах хугацааг шинжилгээний дүн гарсан өдрөөс хойш тооцно.

24.3.Шалгалтын танилцуулга нь шалгалтын талаарх ерөнхий мэдээлэл, түүний үр дүн, тогтоогдсон нөхцөл байдал, авсан болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, дүгнэлтийг агуулсан байна.

24.3.Шалгуулагч этгээдэд шалгалтын дүнг танилцуулна.

25 дугаар зүйл. Гүйцэтгэлийн шалгалт

25.1.Улсын байцаагч хяналт шинжилгээ болон өмнөх шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар өгсөн улсын байцаагчийн албан шаардлагын биелэлтэд үнэлэлт дүгнэлт өгөх зорилгоор гүйцэтгэлийн шалгалт явуулж болно.

25.2.Гүйцэтгэлийн шалгалтыг гагцхүү өмнөх шалгалтаар өгсөн улсын байцаагчийн албан шаардлагад дурдсан асуудлын хүрээнд хийнэ.

25.3.Улсын байцаагчаас өгсөн албан шаардлагын биелэлтийг хэрхэн хангасан талаар шалгуулагч этгээдээс ирүүлсэн хариуг үндэслэн гүйцэтгэлийн шалгалт хийх эсэхийг ажлын таван өдрийн дотор шийдвэрлэнэ.

25.4.Улсын байцаагч дараах тохиолдолд гүйцэтгэлийн шалгалтыг заавал хэрэгжүүлнэ:

25.4.1.үйл ажиллагаа, ашиглалтыг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоосон;

25.4.2.бараа, бүтээгдэхүүн, эд зүйлийг хураан авсан, битүүмжилсэн;

Дөрөвдүгээр дэд бүлэг
Шалгалтын хүрээнд авах арга хэмжээ

26 дугаар зүйл. Бараа, бүтээгдэхүүн, тээврийн хэрэгслийг түр саатуулах

26.1.Улсын байцаагч зохих шаардлагад нийцэхгүй байж болзошгүй бараа, бүтээгдэхүүнд мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах, дээж авч шинжилгээнд хамруулах, холбогдох байгууллагаас мэдээлэл, лавлагаа авах, баримт бичгийн бүрдлийг хангуулах зорилгоор бараа, бүтээгдэхүүн, тээврийн хэрэгслийг түр саатуулж болно.

26.2.Хадгалалтын тусгай нөхцөл шаардагдах, түргэн муудах бараа, бүтээгдэхүүнийг стандартын шаардлага хангасан агуулахад хадгалах, боломжгүй тохиолдолд эзэмшигчийнх нь агуулах, байр, саванд хадгалуулж болно.

26.3.Хуульд өөрөөр заагаагүй бол бараа, бүтээгдэхүүн, тээврийн хэрэгслийг түр саатуулах хугацаа ажлын 10 хүртэл хоног байна.

26.4.Энэ хуулийн 26.3-т заасан хугацаанд шалгуулагч этгээд зөрчил дутагдлаа залруулсан эсхүл тухайн бараа, бүтээгдэхүүн нь зохих шаардлагад нийцсэн нь тогтоогдсон тохиолдолд улсын байцаагч бараа, бүтээгдэхүүн, тээврийн хэрэгслийг түр саатуулсан шийдвэрийг нэн даруй цуцална.

27 дугаар зүйл. Бараа, бүтээгдэхүүнийг буцаах

27.1.Улсын байцаагч шалгуулагч этгээд бараа, бүтээгдэхүүн, тээврийн хэрэгслийг түр саатуулсан хугацаанд зөрчил дутагдлаа залруулаагүй, түүнчлэн импортлохыг хориглосон, лабораторийн шинжилгээгээр эсхүл шалгалтаар чанар, аюулгүй байдал нь алдагдсан, дагалдах бичиг баримт хуурамч болох нь тогтоогдсон бараа, бүтээгдэхүүнийг экспортлогч улсад буцаах арга хэмжээ авна.

28 дугаар зүйл. Бараа, бүтээгдэхүүнийг татан авах

28.1.Иргэн, хуулийн этгээд нь тухайн бараа, бүтээгдэхүүнээс шалтгаалсан өвчлөл гарсан, шалгалтаар зохих шаардлагад нийцэхгүй болох нь тогтоогдсон, эсхүл энэ тухай эрх бүхий олон улсын байгууллагын мэдээлэл, зөвлөмжөөр мэдээлэгдсэн бараа, бүтээгдэхүүнийг өөрийн санаачилгаар эсхүл улсын байцаагчийн шийдвэрээр зах зээлээс татан авах үүрэгтэй.

28.2.Шалгуулагч этгээд энэ хуулийн 28.1-т заасны дагуу бараа, бүтээгдэхүүнээ татан авсан тохиолдолд хяналтын байгууллагын шийдвэрийг гартал бараа, бүтээгдэхүүнийг татан авсан он, сар, өдрийг тэмдэглэн тухайн бараа, бүтээгдэхүүнийг тусгаарлан битүүмжилж хадгална.

28.3.Татан авсан бараа, бүтээгдэхүүнтэй холбоотой засах боломжтой зөрчил дутагдлыг улсын байцаагчийн хяналтан дор арилгаж, улсын байцаагчийн шийдвэрээр зах зээлд дахин нийлүүлж болно.

28.4.Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд аюултай, гарал үүсэл нь тодорхойгүй бараа, бүтээгдэхүүнийг энэ хуулийн 19.7-т заасан журмын дагуу устгана.

28.5.Энэ хуулийн 28.2-28.4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлсэнтэй холбогдон гарсан зардал, лабораторийн шинжилгээний төлбөр, бусдад учирсан хохирлыг буруутай этгээд хариуцна.

28.6.Хяналтын байгууллага энэ хуулийн 28.1-т заасны дагуу татан авсан бараа, бүтээгдэхүүний талаар мэдээллийн сан бүрдүүлж, нийтэд мэдээлнэ.

29 дүгээр зүйл. Хураан авах, битүүмжлэх

29.1.Улсын байцаагч дараах тохиолдолд бараа, бүтээгдэхүүн, эд зүйлийг хураан авах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

29.1.1.шалгалтаар хууль, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актаар худалдан борлуулах, эзэмших, ашиглахыг хориглосон бараа, бүтээгдэхүүн, эд зүйл илэрсэн;

29.1.2.шалгуулагч этгээд энэ хуулийн 27.1, 28.1-д заасны дагуу гаргасан улсын байцаагчийн шийдвэрийг тогтоосон хугацаанд сайн дураар биелүүлээгүй;

29.1.3.тухайн бараа, бүтээгдэхүүн, эд зүйл нь хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд аюултай болох нь тогтоогдсон;

29.1.4.хуульд заасан бусад.

29.2.Энэ хуулийн 29.1-д заасны дагуу хураан авах бараа, бүтээгдэхүүн, эд зүйл нь овор хэмжээ, эсхүл бусад шалтгаанаар хадгалах боломжгүй бол тухайн газарт нь болон бусад зориулалтын байгууламжид битүүмжилж, лацдах арга хэмжээ авч болно.

29.3.Энэ хуулийн 30.1-д заасан улсын байцаагчийн шийдвэрийг шалгуулагч этгээд биелүүлээгүй бол тухайн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг битүүмжилж, лацдах арга хэмжээг авна.

29.4.Энэ хуулийн 29.2, 29.3-т заасны дагуу бараа, бүтээгдэхүүн, эд зүйл, барилга байгууламж, тоног төхөөрөмжийг битүүмжлэхдээ тэдгээрийг бусдад шилжүүлэх, ашиглуулах, устгах, өөрчлөх, захиран зарцуулах, хөдөлгөхийг хориглож, шалгуулагч этгээдэд өөрт нь, эсхүл бусад хамаарал бүхий этгээдэд чанар аюулгүй байдлыг алдагдуулахгүйгээр хадгалж, хамгаалах үүрэг хүлээлгэнэ.

29.5.Улсын байцаагч энэ хуулийн 29.4-т заасны дагуу тухайн эд зүйл, барилга байгууламж, тоног төхөөрөмжийг хадгалах, хамгаалах үүрэг хүлээсэн хүнд шийдвэрийн хувийг өгч, үүргээ зөрчвөл хуульд заасан хариуцлага хүлээлгэх тухай сануулна.

29.6.Улсын байцаагч хураан авах, битүүмжлэх арга хэмжээг авахдаа тэмдэглэл үйлдэж, нэг хувийг шалгуулагч этгээдэд өгнө.

29.7.Хурааж авсан бараа, бүтээгдэхүүн, эд зүйлийг улсын орлого болгох, худалдан борлуулах, устгах журмыг Засгийн газар батална.

30 дүгээр зүйл. Үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох

30.1.Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд хор хохирол учруулж байгаа, эсхүл учруулж болох нөхцөл байдал үүссэн, түүнчлэн зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулсан тохиолдолд шалгуулагч этгээдийн ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн, эсхүл барилга байгууламж, үйл ажиллагаандаа ашиглаж байгаа тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалтыг шалгуулагч этгээд зөрчил дутагдлаа арилгах хүртэл хугацаанд түр зогсооно.

30.2.Улсын байцаагч ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг түр зогсоосон тохиолдолд шалгуулагч этгээдэд актын хувийг гардуулна.

30.3.Улсын байцаагч нь ажил, үйлдвэрлэл, үйлчилгээг бүхэлд нь, хэсэгчлэн, эсхүл барилга байгууламж, машин, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалтыг түр зогсоосон талаар хэвлэл, мэдээлэлийн хэрэгслээр олон нийтэд мэдээлж болно.

30.4.Хуулийн этгээдийн үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох акт гаргасны дараа тусгай хадгалалт, хамгаалалт шаардлагатай хөрөнгө, барааг тухайн байгууллагаас өөр байгууллагад хадгалуулж болно.

30.5.Шалгуулагч этгээд зөрчлөө арилгасан тухай хяналт шалгалтын байгууллагад мэдэгдсэн тохиолдолд улсын байцаагч нэн даруй гүйцэтгэлийн шалгалт хийж үйл ажиллагаа, ашиглалтыг сэргээх эсэхийг шийдвэрлэнэ.

30.6.Улсын байцаагч шаардлагатай зүйлийг ариутгах, хоргүйжүүлэх, цэвэршүүлэх, засвар, үйлчилгээ хийхийг шалгуулагч этгээдэд даалгаж болно.

31 дүгээр зүйл. Хохирол арилгуулах

31.1.Шалгуулагч этгээд хууль бусаар орлого олсон, бусдад хохирол учруулсан нь тогтоогдсон тохиолдолд улсын байцаагч төлбөрийн акт тогтоож, хохирлыг арилгуулах арга хэмжээг авна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ УЛСЫН БАЙЦААГЧ

32 дугаар зүйл. Улсын байцаагчийн эрх олгох, түдгэлзүүлэх, цуцлах

32.1.Хуульд өөрөөр заагаагүй бол улсын ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газар олгоно.

32.2.Улсын ерөнхий байцаагч нь харьяа улсын байцаагч, улсын ахлах байцаагчийн эрхийг олгох, түдгэлзүүлэх, цуцлах асуудлыг шийдвэрлэнэ.

32.3.Хуулиар улсын байцаагчийн эрхтэй байхаар заасан бусад этгээдэд улсын байцаагч, улсын ахлах байцаагчийн эрхийг олгох, түдгэлзүүлэх, цуцлах асуудлыг мэргэжлийн хяналтын улсын ерөнхий байцаагч шийдвэрлэнэ.

33 дугаар зүйл. Улсын байцаагчийн нийтлэг бүрэн эрх, хүлээх үүрэг

33.1.Улсын байцаагч хяналт шалгалт хэрэгжүүлэхдээ дараах бүрэн эхийг хэрэгжүүлнэ:

33.1.1.хяналт шалгалтын объектод саадгүй нэвтрэн орох;

33.1.2.хяналт шалгалтын объект, үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

33.1.3.цахим болон цаасан суурьтай баримт бичиг, мэдээлэлтэй танилцах, үнэ төлбөргүйгээр гаргуулан авах;

33.1.4.тайлбар авах;

33.1.5.үзлэг, туршилт, хэмжилт, магадлал хийх;

33.1.6.шинжилгээнд хамруулахаар дээж авах;

33.1.7.шалгалтын үйл явцыг дуу, дүрсний хэрэгсэл ашиглан бэхжүүлж авах;

33.1.8.ариутгах, хоргүйжүүлэх, саармагжуулах, халдваргүйжүүлэх, цэвэршүүлэх арга хэмжээ авах;

33.1.9.ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоох, битүүмжлэх;

33.1.10.бараа, бүтээгдэхүүн, тээврийн хэрэгслийг түр саатуулах;

33.1.11.зохих шаардлагад нийцээгүй болох нь тогтоогдсон бараа, бүтээгдэхүүнийг худалдахыг хориглох, зах зээлээс татан авахуулах, хураан авах, экспортлогч орон руу буцаах, устгах талаар шийдвэр гаргах, энэ тухай олон нийтэд зарлан мэдээлэх;

33.1.12.хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох этгээдэд хугацаатай албан шаардлага өгч, биелэлтийг хангуулах;

33.1.13.иргэн, хуулийн этгээдийн хууль бусаар олсон орлого, эд зүйлийг улсын орлого болгох, бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх;

33.1.14.шалгуулагч этгээд шалгалт хийлгэхээс зайлсхийсэн, улсын байцаагчийн хууль ёсны шаардлага, хүчин төгөлдөр шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд албадлага хэрэглэх тухай шийдвэр гаргах;

33.1.15.хуульд заасан бусад бүрэн эрх.

33.2.Улсын ахлах байцаагч энэ хуулийн 33.1-д заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

33.2.1.холбогдох байгууллагатай тохиролцон зохих мэргэжлийн хүнийг хяналт шалгалтын үйл ажиллагаанд татан оролцуулах, шаардлагатай асуудлыг магадлах зорилгоор лабораторийн буюу магадлан шинжилгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх;

33.2.2.улсын байцаагчийн шийдвэрээр тогтоосон хугацаанд зөрчил дутагдлаа арилгаагүй иргэн, хуулийн этгээдийн тухайн үйлдвэрлэл, үйлчилгээг бүрмөсөн зогсоох, холбогдох тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгуулах тухай санал, дүгнэлтээ эрх бүхий этгээдэд тавьж шийдвэрлүүлэх;

33.2.3.хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдал нь гэмт хэргийн шинжтэй байвал холбогдох нотлох баримтыг эрх бүхий байгууллагад шилжүүлэн шалгуулах;

33.2.4.хяналт шалгалтын удирдамжийг батлах;

33.2.5.улсын байцаагчийн шийдвэр, үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх;

33.2.6.ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоох, битүүмжлэх, бараа, тээврийн хэрэгслийг түр саатуулах, барааг татан авах, буцаах, эд зүйлийг битүүмжлэх, хураан авах, устгах, нөхөн төлбөр тогтоох талаар гаргасан улсын байцаагчийн шийдвэрт шалгуулагч этгээд гомдол гаргасан эсэхээс нь үл хамааран шийдвэрийг гаргаснаас хойш ажлын 5 өдрийн дотор хянан үзэх;

33.2.7.улсын байцаагчийн үйл ажиллагаа, ажлын гүйцэтгэлд хяналт тавих.

33.3.Улсын ерөнхий байцаагч нь энэ хуулийн 33.1, 33.2-т заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

33.3.1.улсын байцаагч, улсын ахлах байцаагчийн эрх олгох, түдгэлзүүлэх, цуцлах;

33.3.2.тухайн жилд хэрэгжүүлэх хяналт шалгалтын төлөвлөгөөг батлах.

33.4.Хуульд өөрөөр заагаагүй бол улсын ерөнхий байцаагч зарим бүрэн эрхээ доод шатны улсын байцаагчид шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь улсын ерөнхий байцаагчийг хуулиар хүлээсэн үүрэг, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

33.5.Энэ хуулийн 33.1, 33.2-т заасан бүрэн эрхийг улсын ахлах байцаагчгүй суманд сумын мэргэжлийн хяналтын улсын байцаагч хэрэгжүүлнэ.

33.6.Улсын байцаагч хяналт шалгалт хэрэгжүүлэхдээ дараах үүргийг хүлээнэ:

33.6.1.хөндлөнгийн нөлөөнд үл автан албан үүргээ хуулийн дагуу, шударгаар гүйцэтгэх;

33.6.2.иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;

33.6.3.өөртэйгөө хамаарал бүхий болон нэгдмэл сонирхолтой этгээдэд холбогдох хяналт шалгалтын ажиллагаанд оролцохоос татгалзах;

33.6.4.хувь хүн, байгууллага, төрийн болон албаны нууцыг үл задруулах;

33.6.5.хийсэн шалгалт, гаргасан шийдвэр, түүний тоо, баримтын үндэслэл, нотолгооны үнэн зөвийг бүрэн хариуцах;

33.6.6.шалгалтыг бүрэн гүйцэд хийх;

33.6.7.хуульд заасан бусад үүрэг.

33.7.Хуулиар тусгайлан эрх олгогдсон улсын байцаагчийн эрхтэй бусад этгээд нь энэ хуулийн 33.6-д заасан үүргээс гадна дараах үүргийг хүлээнэ:

33.7.1.улсын ерөнхий байцаагчтай байгуулсан гэрээнд заасан хамрах хүрээнд хяналт шалгалтыг хэрэгжүүлэх;

33.7.2.хяналт шалгалтыг давхардуулахгүй байлгах шаардлагыг хангах зорилгоор тухайн жилд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөг мэргэжлийн хяналтын төв байгууллагатай урьдчилан зөвшилцөж, тухайн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдөр батлуулах;

33.7.3.шалгалт хийсэн тухай бүрт шалгалтын дүн, тайлангаа тухай бүр мэргэжлийн хяналтын төв байгууллагад хүргүүлэх.

33.8.Энэ хуулийн 33.7-д заасныг зөрчсөн нь тухайн улсын байцаагчийн эрхийг түдгэлзүүлэх, цуцлах үндэслэл болно.

34 дүгээр зүйл. Улсын байцаагчийн гаргах шийдвэр

34.1.Улсын байцаагч хяналт шалгалтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ импортын мэдэгдэл, экспорт, импортын гэрчилгээ, зөвлөмж, мэдэгдэл, дүгнэлт, албан шаардлага, акт болон мэргэжлийн хяналтын байгууллагын үйлдэх бусад баримт бичиг үйлдэж баталгаажуулна.

34.2.Улсын байцаагч энэ хуулийн 34.1-д заасан баримт бичгийг дараах үндэслэлээр үйлдэнэ:

34.2.1.хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг хэрхэн мөрдөж ажиллах арга, хэлбэрийн талаар зөвлөмж үйлдэнэ;

34.2.2.бараа, бүтээгдэхүүн, тээврийн хэрэгслийг түр саатуулах, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бусад бараа, бүтээгдэхүүнийг хил дээрээс экспортлогч оронд буцаах болон зорчигч, бараа, тээврийн хэрэгслийг хилийн боомт, гүний гаалийн хяналтын бүсээр нэвтрүүлэх үеийн хяналт шалгалтад тухай мэдэгдэл үйлдэнэ;

34.2.3.хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, залруулах, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар хугацаатай албан шаардлага үйлдэнэ;

34.2.4.холбогдох зөвшөөрлийг хүчингүй болгуулах талаар эрх бүхий этгээдэд санал хүргүүлэх, барилга байгууламж, бараа бүтээгдэхүүн, ажил, үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, аюулгүй байдал нь хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актын шаардлагыг хангаж байгаа эсэхийг тодорхойлоход дүгнэлт үйлдэнэ;

34.2.5.барилга байгууламж, тоног төхөөрөмжийн ашиглалтыг түр зогсоох, дээж авч шинжилгээнд хамруулах, хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актад заасан зохих зөвшөөрөл, дагалдах баримт бичиггүй, лабораторийн

шинжилгээ, мэдрэхүйн эрхтний үзүүлэлтээр шаардлага хангаагүй бараа, бүтээгдэхүүнийг худалдан борлуулахыг хориглох, татан авахуулах, хураах, өөр зориулалтаар ашиглах, устгах, улсын орлого болгох, шаардлагатай зүйлийг ариутгах, хоргүйжүүлж цэвэршүүлэх, иргэн, хуулийн этгээдийн хууль бусаар олсон орлого, эд зүйлийг хураан авах, улсын орлого болгох, учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, актын үйлчлэлийг дуусгавар болгож үйл ажиллагааг сэргээхэд акт үйлдэнэ.

34.3.Улсын байцаагч гаргасан шийдвэртээ уг шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд гомдлыг хандан гаргах этгээд болон хугацааг тодорхой заана.

34.3.Улсын байцаагчийн гаргах шийдвэрийн загвар, маягт, хэвлэмэл хуудсыг мэргэжлийн хяналтын төв байгууллагын дарга батална.

35 дугаар зүйл. Гомдол гаргах эрх

35.1.Шалгуулагч этгээд улсын байцаагчийн шийдвэр, үйл ажиллагааг эс зөвшөөрвөл дээд шатны улсын байцаагчид гомдол гаргах эрхтэй.

35.2.Улсын байцаагчийн шийдвэр, үйл ажиллагаанд гомдол гаргах, түүнийг шийдвэрлэхэд Захиргааны ерөнхий хуулийн Есдүгээр бүлэгт заасан журам үйлчилнэ.

36 дугаар зүйл. Улсын байцаагчийн шийдвэрийг биелүүлэх

36.1.Улсын байцаагчийн шийдвэрийг холбогдох этгээд заавал биелүүлж, хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар бичгээр хариу мэдэгдэх үүрэгтэй.

36.2.Улсын байцаагчийн тогтоосон төлбөрийн актыг шалгуулагч этгээд сайн дураар биелүүлээгүй бол улсын байцаагчийн шийдвэрийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 284 дүгээр зүйлд заасны дагуу шүүхээр баталгаажуулан шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаар албадан гүйцэтгүүлнэ.

36.3.Энэ хуулийн 36.1-д зааснаас бусад улсын байцаагчийн шийдвэр болон улсын байцаагчийн хууль ёсны шаардлагыг холбогдох этгээд сайн дураар биелүүлээгүй тохиолдолд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх, эсхүл албадлага хэрэглэх тухай шийдвэр гаргана.

36.5.Улсын байцаагчийн хууль ёсны шаардлага болон хүчин төгөлдөр болсон шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй тохиолдолд албадан гүйцэтгэхтэй холбоотой гарсан зардлыг шалгуулагч этгээд нөхөн төлөх үүрэгтэй.

36.6.Тухайн хүн, хуулийн этгээдэд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага хүлээсэн нь улсын байцаагчийн шийдвэрт заасан үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

36.7.Улсын байцаагчийн шийдвэрийг албадан биелүүлэхэд Захиргааны ерөнхий хуулийн Наймдугаар бүлэгт заасан журмыг баримтална.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ
ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ**

37 дугаар зүйл. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх

37.1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хяналт шалгалтын талаар дараах эрх эдэлнэ:

37.1.1.улсын байцаагчийн ажлын үнэмлэх, хяналт шалгалтын удирдамжтай танилцах;

37.1.2.хяналт шалгалтын байгууллага өөрийн бүрэн эрхэд үл хамаарах, эсхүл тухайн шалгалттай холбоогүй асуудлаар баримт бичиг, мэдээлэл шаардвал түүнийг биелүүлэхээс татгалзах;

37.1.3.хяналт шалгалтын удирдамжид ороогүй асуудлаар болон шалгалтын нийт хугацаа хэтэрсэн бол шалгалт хийлгэхээс татгалзах;

37.1.4.хяналт шалгалтын дүн, улсын байцаагчийн үйлдсэн баримт бичигтэй танилцах, хуулбарлаж авах, санал, хүсэлт гаргах;

37.1.5.хяналт шалгалтад биечлэн байлцах буюу төлөөлөгчөө байлцуулах, шалгалтад хамаарах асуудлаар тайлбар гаргах;

37.1.6.шинжилгээний байгууллагын дүгнэлттэй танилцах, тайлбар гаргах;

37.1.7.өөрийн үйл ажиллагаандаа хамааралтай нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт, стандартын талаар мэдээлэл авах;

37.1.8.улсын байцаагчийн шийдвэр, үйл ажиллагааг эс зөвшөөрвөл дээд шатны улсын байцаагч болон удирдах албан тушаалтанд гомдол гаргаж, шийдвэрлүүлэх;

37.1.9.хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт, стандартыг сахин биелүүлэх талаар бусад иргэн, аж ахуйн нэгж байгууллагад шаардлага тавих, уг асуудлаар хяналт шалгалтын байгууллагад өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх;

37.1.9.хуульд заасан бусад эрх.

38 дугаар зүйл. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг

38.1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хяналт шалгалттай холбоотой дараах үүргийг хүлээнэ:

38.1.1.үйл ажиллагаандаа хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт, стандартаар тогтоосон шаардлагыг сахин биелүүлэх, эрсдэлийг бууруулах дотоод хяналт шалгалтын журмыг батлан мөрдөх;

38.1.2.улсын байцаагч хуулиар олгосон бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх, хамтран ажиллах;

38.1.3.улсын байцаагчийг хяналт шалгалтын объектод саадгүй нэвтрүүлэх, шалгалтын ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөхгүй, саад болохгүй байх;

38.1.4.улсын байцаагчаас шаардсаны дагуу хяналт шалгалтад шаардлагатай баримт бичиг, мэдээллийг гаргаж өгөх;

38.1.5.дээж авах боломж, нөхцөлөөр хангах;

38.1.6.улсын байцаагчийн хууль ёсны шаардлага, хууль бус үйл ажиллагаагаа зогсоох, зөрчил дутагдлаа залруулах талаарх улсын байцаагчийн гаргасан шийдвэрийг биелүүлэх;

38.1.7.хүний эрүүл мэнд, амь нас, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй гэж үзвэл зах зээлд нийлүүлсэн бараа, бүтээгдэхүүнээ зах зээлээс буцаан татах;

38.1.8.хуульд заасан бусад үүрэг.

39 дүгээр зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын дотоод хяналт шалгалт

39.1.Аж ахуйн нэгж, байгууллагын дотоод хяналт шалгалтын зорилго нь үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээний аюулгүй байдлыг хангахад чиглэнэ.

39.2.Дотоод хяналт шалгалт нь хууль дээдлэх, хараат бус, ил тод, шударга, бодитой байх зарчимд үндэслэнэ.

39.3.Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмыг Засгийн газар батална.

39.4.Дотоод хяналтын хүрээнд аж ахуйн нэгж, байгууллага нь дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

39.4.1.энэ хуулийн 39.3-т заасан журмыг үндэслэн үйл ажиллагаандаа мөрдөх дотоодын хяналт шалгалт хийх журмыг баталж мөрдүүлэх;

39.4.2.үйл ажиллагаандаа эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлтэй цэгийг тогтоох;

39.4.3.эрсдэлтэй цэгт байнгын хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгах, аюулаас сэргийлэх зохистой дадлыг хэвшүүлэх;

39.4.4.хяналт тавьсан тухай бүрт бүртгэл хөтлөх;

39.4.5.аюулгүй байдлыг хангахтай холбоотой хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандартын талаар ажилтнууддаа сургалт явуулах, мэдээллээр хангах;

39.4.6.дотоод хяналтын үйл ажиллагааны мэдээллийн сан бүрдүүлэх.

40 дүгээр зүйл. Хяналт шалгалтын үйл ажиллагаанд бусад этгээдийг татан оролцуулах

40.1.Хяналт шалгалтын үйл ажиллагаанд шаардлагатай тохиолдолд төрийн бус байгууллага, шинжээч, шинжилгээний байгууллага, холбогдох мэргэжилтэн, хэвлэл мэдээллийн байгууллага, иргэнийг татан оролцуулж болно.

40.2.Хяналт шалгалтын байгууллага хуулиар хүлээлгэсэн тодорхой чиг үүргээ хуульд заасан журмын дагуу гэрээний үндсэн дээр төрийн бус байгууллага, мэргэжлийн хувийн эрх зүйн хуулийн этгээдэд шилжүүлэн гүйцэтгүүлж болно.

41 дүгээр зүйл. Олон нийтийн хяналт

41.1.Хяналт шалгалтын байгууллага нь аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон эрх зүйн актыг сахин биелүүлэх талаар олон нийтийг хамарсан үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

41.2.Хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон эрх зүйн актыг сахин биелүүлэх талаар олон нийт нь бие биедээ шаардлага тавих, уг асуудлаар хяналт шалгалтын байгууллагад өргөдөл, гомдол гаргах эрхтэй.

41.3.Хэрэглэгч, үйлчлүүлэгч нь аюулгүй байдал, чанарын шаардлага хангасан бараа, бүтээгдэхүүн хэрэглэх, ажил, үйлчилгээ авах, орчны аюулгүй байдлаа хангуулах, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээнээс үүсч болох аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлж, дор дурдсан хэлбэрээр хяналт шалгалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ:

41.3.1.аюулгүй бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ сонгон хэрэглэж, эрүүл мэндээ хамгаалах;

41.3.2.аюулгүй байдлыг бүрэн хангасан бараа бүтээгдэхүүн хэрэглэх талаар мэдлэг олж авах, арга барил эзэмших;

41.3.3.эрх бүхий байгууллагаас баталсан стандарт, техникийн нөхцөл, аюулгүйн шаардлага, бараа, ажил, үйлчилгээний талаарх үнэн, бодит мэдээлэл олж авах;

41.3.4.хэрэглэгчийн хяналтын хуудсыг ашиглан бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд үнэлгээ өгөх;

41.3.5.бүтээгдэхүүн, үйлчилгээ, түүний аюулгүй байдлын талаарх баримтанд тулгуурласан, сонголт хийхэд дэмжлэг, туршлага болохуйц үнэн, бодит, мэдээллийг олон нийтэд түгээх;

41.3.6.эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангаагүй, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлсэн болон үзүүлж болзошгүй, буруу шошголсон хүнсний болон хүнсний бус бараа, бүтээгдэхүүн, хуурамч түүхий эд, бүтээгдэхүүний талаарх мэдээллийг баримтжуулж, тухайн аж ахуйн нэгж, бизнес эрхлэгч болон холбогдох хяналт шалгалтын байгууллагад мэдэгдэх.

41.4.Хяналт шалгалтын байгууллага нь хяналт шалгалтын үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах, олон нийтийн хяналтыг дэмжих, хөгжүүлэх

зорилгоор шинжлэх ухааны ололт, орчин үеийн мэдээллийн технологийн арга, хэлбэрийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, түүнийг боловсронгуй болгох арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГА

Нэгдүгээр дэд бүлэг Мэргэжлийн хяналтын байгууллагын тогтолцоо, бүтэц, бүрэлдэхүүн

42 дугаар зүйл. Мэргэжлийн хяналтын байгууллагын тогтолцоо

42.1.Мэргэжлийн хяналтын байгууллага нь энэ хуулийн 48 дугаар зүйлд заасан хяналт шалгалтын хамрах хүрээнд үндэсний аюулгүй байдал, хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны улмаас хүний амь нас, эрүүл мэнд болон хүрээлэн буй орчинд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хууль, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт, стандартын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх чиг үүрэгтэй байна.

42.2.Мэргэжлийн хяналтын байгууллага нь нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байх бөгөөд мэргэжлийн хяналтын төв байгууллага, аймаг, нийслэл, хил, гүний мэргэжлийн хяналтын газар, дүүргийн мэргэжлийн хяналтын хэлтэс, сумын мэргэжлийн хяналтын тасаг, улсын байцаагчаас бүрдэнэ.

42.3.Хүн амын нягтаршил, үүсч болзошгүй аюул, эрсдэлийг харгалзан мэргэжлийн хяналтын төв байгууллагын саналаар сумын мэргэжлийн хяналтын тасгийг Засгийн газар байгуулж болно.

42.4.Мэргэжлийн хяналтын байгууллагад нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байх зарчим дараах байдлаар хэрэгжинэ:

42.4.1.дээд шатны мэргэжлийн хяналтын байгууллага, улсын байцаагчийн хууль ёсны шийдвэрийг доод шатны мэргэжлийн хяналтын байгууллага, улсын байцаагч заавал биелүүлэх;

42.4.2.улсын байцаагч дээд шатны улсын байцаагчийн өмнө ажлаа хариуцах;

42.4.3.дээд шатны улсын байцаагч доод шатны улсын байцаагчийн үйл ажиллагаа, шийдвэрийн талаархи гомдлыг хянан шийдвэрлэх, хууль бус, үндэслэлгүй шийдвэрийг хүчингүй болгох, өөрчлөх;

42.5.Мэргэжлийн хяналтын байгууллагын дэргэд лаборатори, сургалт, судалгааны, мэдээлэл, технологийн төв байна.

42.6.Мэргэжлийн хяналтын байгууллагыг улсын төсвөөс санхүүжүүлэх бөгөөд энэхүү төсөв нь уг байгууллага чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байна.

42.7.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь харьяа нутаг дэвсгэр дэх мэргэжлийн хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу

эзэмшлийн газар олгож, холбоо, эрчим хүч, дулаанаар саадгүй үйлчилж, үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөлөөр хангана.

42.8.Мэргэжлийн хяналтын байгууллага хөгжлийн хөтөлбөртэй байх бөгөөд хөгжлийн хөтөлбөрийг Засгийн газар батална.

42.9.Мэргэжлийн хяналтын байгууллага нь бэлгэ тэмдэгтэй байх бөгөөд түүний загвар, хэрэглэх журмыг мэргэжлийн хяналтын төв байгууллагын дарга батална.

43 дугаар зүйл. Мэргэжлийн хяналтын байгууллагын чиг үүрэг

43.1.Мэргэжлийн хяналтын байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

43.1.1.мэргэжлийн хяналтын хамрах хүрээний асуудлаар өмчийн хэлбэр харгалзахгүйгээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хуульд заасан үндэслэл, журмын дагуу шалгалт хийх, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, залруулах арга хэмжээ авах;

43.1.2.тандалт судалгаа, хяналт шинжилгээ хийх, салбарын нийтлэг асуудлаар сургалт зохион байгуулах, хяналтын хуудсын хүрээнд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх;

43.1.3.хуульд заасны дагуу зөвшөөрөл, гэрчилгээ, мэдэгдэл олгох, дүгнэлт гаргах замаар хянан баталгаажуулах үйл ажиллагаа явуулах;

43.1.4.эрсдэл, аюул, осол үүсгэж болзошгүй объект, үйл ажиллагааг тодорхойлж, тэдгээрийн эрсдэлийг үнэлэх, шалтгаан, нөхцөлийг тогтоох, эрсдэлийг бууруулах, арилгах арга хэмжээг авах, үр дүнг нийтэд мэдээлэх;

43.1.5.хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт, стантартыг боловсронгуй болгох талаар холбогдох байгууллагад санал хүргүүлж, шийдвэрлүүлэх;

43.1.6.лабораторийн шинжилгээ хийх;

43.1.7.хуульд заасан бусад чиг үүрэг.

43.2.Мэргэжлийн хяналтын байгууллага нь улсын төсөвт орлого төвлөрүүлэх чиг үүргийг хүлээхгүй.

43.3.Мэргэжлийн хяналтын байгууллагаас хэрэгжүүлсэн хяналт шалгалтын дүнд улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын 20-иос доошгүй хувийг мэргэжлийн хяналтын байгууллага, лабораторийн үйл ажиллагааг дэмжих, хүний нөөцийг чадавхижуулах үйл ажиллагаанд санхүүжүүлнэ.

43.4.Энэ хуулийн 43.3-т заасан хөрөнгийг хуваарилах, зарцуулах, тайлагнах журмыг мэргэжлийн хяналтын болон төсвийн асуудал эрхэлсэн сайд хамтран батална.

44 дүгээр зүйл. Мэргэжлийн хяналтын төв байгууллагын бүрэн эрх

44.1.Мэргэжлийн хяналтын төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

44.1.1.мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангах, үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх;

44.1.2.хяналт шалгалтын бодлого, эрсдэлийн удирдлагын стратегийг тодорхойлж, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнах ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах;

44.1.3.хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотой хуульд заасан дүрэм, журам, заавар, аргачлал, стандарт, хяналтын хуудсыг боловсруулж батлах;

44.1.4.хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шаардлагатай тохиолдолд холбогдох олон улсын байгууллагаас мэргэжлийн туслалцаа, дэмжлэг авах;

44.1.5.мэргэжлийн хяналтын байгууллагын хүний нөөцийн хэрэгцээг төлөвлөх, алба хаагчдыг давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, баталгааг хангах ажлыг зохион байгуулах;

44.1.6.хяналт шалгалтын асуудлаар мэдээлэл, зөвлөгөө өгөх, хууль тогтоомж зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах;

44.1.7.гадаад орны мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналтын байгууллагатай амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл мэнд, хорио цээрийн нөхцөлийг тохиролцох, эрсдэлийн хянан магадлагааг хамтран хэрэгжүүлэх;

44.1.8.хяналт шалгалтын статистикийн мэдээлэл, удирдлагын нэгдсэн санг бүрдүүлэх, удирдах зохион байгуулах;

44.1.9.хэвлэлийн бодлого, стратегийг тодорхойлж, хяналт шалгалтын үр дүн, урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлгийг олон нийтэд ил тод хүргэх ажлыг зохион байгуулах;

44.1.10.орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллага, улсын байцаагч болон улсын байцаагчийн эрх авсан бусад этгээдийн шалгалтын үр дүнг үнэлж, дүгнэх;

44.1.11.хуульд заасан бусад бүрэн эрх.

45 дугаар зүйл. Мэргэжлийн хяналтын байгууллагын удирдлага

45.1.Мэргэжлийн хяналтын төв байгууллагын даргыг Монгол Улсын Ерөнхий сайд томилж, чөлөөлнө.

45.2.Аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, сумын мэргэжлийн хяналтын тасгийн даргыг тухайн шатны Засаг даргатай зөвшилцөж, хил, гүний мэргэжлийн хяналтын газар, дүүргийн мэргэжлийн хяналтын хэлтэс, нэгдсэн төв лабораторийн даргыг холбогдох хуульд заасны дагуу мэргэжлийн хяналтын төв байгууллагын дарга тус тус томилно.

45.3.Мэргэжлийн хяналтын төв байгууллагын дарга нь улсын ерөнхий байцаагч байна. Улсын ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газар олгоно.

45.4.Мэргэжлийн хяналтын төв байгууллагын дарга Засгийн газрын агентлагийн тухай хуулийн 8.3-т зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

45.4.1.мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, удирдах;

45.4.2.Төрийн албаны тухай хуульд заасны дагуу мэргэжлийн хяналтын байгууллагын төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийг томилох, чөлөөлөх, халах, шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, сахилгын шийтгэл ногдуулах;

45.4.3.мэргэжлийн хяналтын байгууллагын албан тушаалын тодорхойлолтыг батлах;

45.4.4.Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Улсын Их Хурлын нэгдсэн болон Байнгын хорооны хуралдаанд шаардлагатай тохиолдолд, Засгийн газрын хуралдаанд тогтмол оролцож мэдээлэл өгөх, байгууллагын байр суурийг илэрхийлэх;

45.4.5.энэ хууль болон бусад хуульд заасан дүрэм, журам, хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотой стандарт, заавар, аргачлал, төлөвлөгөө, хяналтын хуудас болон зөвшөөрөл, гэрчилгээ, мэдэгдэл, маягтын загварыг батлах;

45.4.6.алба хаагчдад зориулсан байнгын сургалтын хөтөлбөрийн төлөвлөгөө, мэргэшүүлэх сургалт явуулах журмыг батлах;

45.4.7.орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллага, сургалт, судалгаа, мэдээлэл, технологийн төвийн төсөв, бүтэц, орон тоог батлах;

45.4.8.лабораторийн бүтэц, орон тоо, ажиллах дүрмийг батлах;

45.4.9.зорчигч, бараа, тээврийн хэрэгслийг хилийн боомт, гүний гаалийн хяналтын бүсээр нэвтрүүлэх үеийн шалгалт хийх журмыг батлах;

45.4.10.хуульд заасан бусад бүрэн эрх.

45.5.Мэргэжлийн хяналтын төв байгууллагын дарга бүрэн эрхийнхээ хүрээнд тушаал гаргана.

46 дугаар зүйл. Эрсдэлийн удирдлага

46.1.Мэргэжлийн хяналтын байгууллага нь хяналт шалгалтын үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлагын зарчмыг баримтална.

46.2.Мэргэжлийн хяналтын төв байгууллага энэ хуулийн 46.3-т заасан эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөг батална.

46.3.Иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны эрсдэлийг хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, эдийн засаг, нийгмийн аюулгүй байдалд учруулж

болзошгүй аюул болон түүний хэмжээ, хамрах цар хүрээ, үр дагаврыг харгалзан энэ хуулийн 36.6-д заасан шалгуураар үнэлнэ.

46.4.Эрсдэлийг тодорхойлох, шинжлэх, үнэлэх, дүгнэх үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэлтэй, баримт нотолгоонд тулгуурлан хэрэгжүүлэх ба тэдгээрийг үндэслэн эрсдэлийг арилгах, бууруулахад чиглэсэн арга хэмжээг авна.

46.5.Мэргэжлийн хяналтын байгууллага нь эрсдэлийн удирдлагын стратегитай байна.

46.6.Эрсдэлийн шалгуур, хяналт шалгалтын давтамжийг хяналтын чиглэл бүрээр мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, эрсдэлийн үнэлгээ хийх журмыг мэргэжлийн хяналтын төв байгууллагын дарга тус тус батална.

47 дугаар зүйл. Хяналт шалгалтын статистикийн мэдээлэл, удирдлагын нэгдсэн сан

47.1.Мэргэжлийн хяналтын байгууллага хяналт шалгалтын мэдээллийн нэгдмэл байдлыг хангах, зөрчил дутагдлын шалтгаан, нөхцөлийг тогтоох, эрсдэлээс урьдчилан сэргийлэх нэгдсэн бодлого боловсруулах, иргэн, хуулийн этгээдэд шуурхай үйлчилгээ үзүүлэх зорилгоор хяналт шалгалтын статистикийн мэдээлэл, удирдлагын нэгдсэн сан /цаашид “Мэдээллийн сан” гэх/-тай байна.

47.2.Мэргэжлийн хяналтын байгууллага төрийн бусад байгууллагын цахим сан, камер, сүлжээ, технологи болон мэдээллийн санг хяналт шалгалтын үйл ажиллагаанд үнэ төлбөргүй ашиглах эрхтэй.

47.3.Улсын байцаагч хяналт шалгалт хийсэн тухай бүрт хяналт шалгалттай холбогдох баримт бичгийг цахим системд бүртгэж, хөтөлнө.

47.4.Мэдээллийн цахим сангийн хөгжүүлэлт хийх, цахим систем байгуулах болон сервер, компьютерийн үйлдлийн систем, мэдээллийн санд ашиглагдаж буй программыг албан ёсны эрхтэйгээр худалдан авах, ашиглах хугацааг сунгах зардлыг байгууллагын жил бүрийн төсөвт тусгана.

47.5.Мэдээллийн санг бүрдүүлэх, сангийн мэдээллийг хадгалах, хамгаалах, ашиглах, ашиглалтад хяналт тавих журмыг мэргэжлийн хяналтын байгууллагын дарга батална.

Хоёрдугаар дэд бүлэг Мэргэжлийн хяналтын байгууллагаас хэрэгжүүлэх хяналт шалгалтын хамрах хүрээ

48 дугаар зүйл. Хяналт шалгалтын хамрах хүрээ

48.1.Мэргэжлийн хяналтын байгууллага дараах чиглэлээр холбогдох хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт, техникийн зохицуулалт, стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ:

48.1.1.хүрээлэн буй орчны аюулгүй байдал, байгалийн нөөцийн хяналт: хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулж буй бохирдол, химийн хорт болон аюултай бодис, аюултай хог хаягдалын аюулгүй байдал, тэсэрч

дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, бүх төрлийн ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаа, газар, газрын харилцаа, геодези, зураг зүйн, кадастрын хяналт, байгалийн нөөцийн баялгийн зохистой ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлт, хөрсний доройтол, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх, хөрс, ус, агаарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах;

48.1.2.хүнсний аюулгүй байдлын хяналт: хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал алдагдснаас нийтийг хамарсан хоол, хүнсний хордлого, хордлогот халдвар гарахаас урьдчилан сэргийлэх, мал эмнэлгийн ажил үйлчилгээ, мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, тэжээлийн нэмэлт, газар тариалангийн үйлдвэрлэл, үр сорт, ургамал хамгааллын бодис, бордооны чанар, аюулгүй байдлыг хангуулах, таримал ургамлын өвчин, хог ургамал, хөнөөлт шавж, мэрэгч амьтнаас болон мал, амьтны эрүүл мэнд, удмын санг хамгаалж, мал, амьтны халдварт, гоц халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлэх;

48.1.3.зорчигч, бараа, тээврийн хэрэгслийг хилийн боомт, гүний гаалийн хяналтын бүсээр нэвтрүүлэх үеийн хяналт: олон улсын хүний хөл хориот болон мал, амьтны гоц халдварт өвчин, ургамлын гадаад, дотоод хорио цээртэй өвчин, хог ургамал, хөнөөлт шавж, мэрэгч амьтан улсын хилээр нэвтрэх, дамжин тархахаас урьдчилан сэргийлэх, цөмийн материал, цацрагийн үүсгүүрийн хууль бус хөдөлгөөнд хяналт тавих, экспорт, импортын амьтан, ургамал, бодис, бараа, бүтээгдэхүүний эрүүл ахуй, хорио цээр, чанар, аюулгүйн байдлын шаардлагыг хангуулах;

48.1.4.эрүүл ахуй, халдвар хамгаалал, эмчилгээний аюулгүй байдлын хяналт: хүн амын суурьшлын бүсийн агаар, хөрс, ундны усны бохирдол, эмнэлгийн хог хаягдлын аюулгүй байдал, олон нийтийн болон хүнсний үйлдвэр, үйлчилгээний байгууллагын барилга байгууламжийн төлөвлөлт, эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэм зөрчигдөх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал алдагдах, дотоод халдвар гарахаас урьдчилан сэргийлэх;

48.1.5.хөдөлмөрийн харилцаа, аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналт: хүн, хуулийн этгээдийн хөдөлмөрийн харилцаа, иргэдийн хөдөлмөр эрхлэлт, /эмэгтэйчүүд, ахмад настан, тахир дутуу, одой болон насанд хүрээгүй хүн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн/, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй /ажилтны эрүүл мэнд, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл, эрүүл, аюулгүй орчин, техник, тоног төхөөрөмж/-г хангуулж, мэргэжлээс шалтгаалах өвчин, осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх;

48.1.6.нийгмийн хамгааллын хяналт: эрүүл мэнд, нийгмийн даатгал, нийгмийн халамжийн сан, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг бий болгох, өрхийн орлогыг нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрийн хөрөнгийн хууль бус зарцуулалтыг таслан зогсоож, иргэн, даатгуулагчийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх;

48.1.7.санхүүгийн хяналт шалгалт: улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн , тусгай зориулалтын сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, төсвийн болон гадаадын зээл, тусламж, хөрөнгө оруулалтын зүй бус зарцуулалтаас урьдчилан сэргийлэх;

48.1.8.барилга байгууламж, техник, технологийн аюулгүй байдлын хяналт: барилга, эрчим хүч, автозам, төмөр зам, харилцаа холбоо, газрын тос, өргөх байгууламжийн зураг төсөл, усралт, засвар шинэчлэлт, ашиглалт, хэмжих хэрэгсэл, тээврийн хэрэгслийн техникийн аюулгүй байдлыг хангуулах;

48.1.9.цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналт: цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги, цөмийн технологийн ашиглалт, цөмийн материал, цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдал, хүрээлэн буй орчин, бараа, материал, хүнсний бүтээгдэхүүнийг цацрагийн бохирдлоос хамгаалах;

48.1.10.нийгэм, соёлын хяналт: боловсрол сургалтын үйлчилгээний чанар, багш, суралцагчийн аюулгүй байдал, эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөх, соёл, урлагийн байгууллагын үйлчилгээ, соёлын биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалт алдагдахаас сэргийлэх;

48.2.Энэ хуулийн 48.1-д заасан хяналтын хамрах хүрээнд мэргэжлийн хяналтын байгууллагаас хяналт шалгалтыг хэрэгжүүлэх хууль зүйн үндэслэл нь Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх, нийтийн ашиг сонирхлыг хангах, хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд оршино.

48.3.Энэ хуулийн 48.1-д заасан хяналтын хамрах хүрээнд нийцүүлэн мэргэжлийн хяналтын байгууллагаас хэрэгжүүлэх хяналтын чиглэлийн жагсаалтыг мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар батална.

49 дүгээр зүйл. Мэргэжлийн хяналтад хамрагдах этгээд

49.1.Мэргэжлийн хяналтын байгууллагаас хийх хяналт шалгалтад энэ хуулийн 48.1-д заасан хяналт шалгалтын хамрах хүрээнд хуулийн биелэлтийг хангах үүрэг бүхий төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа нэгэн адил хамрагдана.

50 дугаар зүйл. Байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа

50.1.Мэргэжлийн хяналтын байгууллага энэ хуулийн 49.1-д заасан этгээдийн үйл ажиллагааг хянаж шалгахдаа дараах нөхцөл байдлыг тогтооно:

50.1.1.хуулиар хүлээсэн чиг үүргээ зорилгодоо нийцээгүй байдлаар хэтрүүлж хэрэгжүүлсэн эсэх;

50.1.2.хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлээгүй, эсхүл хангалтгүй хэрэгжүүлсэн эсэх;

50.1.3.хуулийг тэгш бусаар, ялгавартайгаар хэрэгжүүлсэн эсэх.

50.2.Энэ хуулийн 50.1-д заасан нөхцөл байдал тогтоогдвол түүний шалтгааныг тодруулж, тухайн этгээдэд өөрт нь эсхүл, дээд шатны байгууллага, албан тушаалтанд хандаж зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээг авна.

Гуравдугаар дэд бүлэг Мэргэжлийн хяналтын улсын байцаагч

51 дүгээр зүйл. Мэргэжлийн хяналтын улсын байцаагч

51.1.Мэргэжлийн хяналтын төв байгууллагад улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч ажиллана.

51.2.Аймаг, нийслэл, хил, гүний мэргэжлийн хяналтын газар, дүүргийн мэргэжлийн хяналтын хэлтэс, сумын мэргэжлийн хяналтын тасагт улсын ахлах байцаагч, улсын байцаагч, суманд улсын байцаагч ажиллана.

51.3.Мэргэжлийн хяналтын улсын байцаагч нь Засгийн газраас загварыг нь баталсан, улсын ерөнхий байцаагчаас олгосон албаны болон хувийн дугаар бүхий үнэмлэх, тэмдэг хэрэглэнэ.

52 дугаар зүйл. Мэргэжлийн хяналтын улсын байцаагчид тавигдах шаардлага

52.1.Хуульд өөрөөр заагаагүй бол улсын байцаагчийн албан тушаалд Төрийн албаны тухай хуульд заасан шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан хүнийг томилно.

52.1.1.тухайн хяналтыг хийх чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн байх;

52.1.2.мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан байх;

52.1.3.улсын байцаагч бэлтгэх сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх.

52.2.Орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагын даргаар мэргэжлийн хяналтын байгууллагад гурваас доошгүй жил ажиллаж байгаа албан хаагчдаас томилно.

53 дугаар зүйл. Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн ажиллах нөхцөл, баталгаа

53.1.Улсын байцаагч Төрийн албаны тухай хууль тогтоомжид заасан төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгаа, түүнд олгох цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал, урамшуулал, тэтгэмжээс гадна дор дурдсан нэмэгдэл баталгаагаар хангагдана:

53.1.1.албан үүргээ хэрэгжүүлэх явцад хот, суурингийн дотор нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр зорчсон тохиолдолд гарсан зардлыг мэргэжлийн хяналтын төв байгууллагын даргын баталсан журмын дагуу байгууллагын төсвийн хөрөнгөөс нөхөн олгох;

53.1.2.улсын байцаагчийн хилийн боомтод ажилласан нэг жилийг нэг жил гурав сар ажилласанд тооцох ба хилийн боомт, аймаг, суманд таваас доошгүй жил ажиллаж байгаа улсын байцаагчид ажилласан таван жил тутам 12 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох;

53.1.3.хилийн боомтод ажиллаж байгаа улсын байцаагчийн гэр бүлийн гишүүнийг ажлаар хангах бөгөөд тэднийг ажлаар хангаагүй нөхцөлд ажилгүй байсан

хугацааны эрүүл мэндийн болон өндөр насны тэтгэврийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож төр хариуцах;

53.1.4.улсын байцаагчийн амь нас, эрүүл мэндийг заавал даатгах бөгөөд даатгалын төлбөрийг тухайн байгууллагын төсвөөс төлөх;

53.1.5.хилийн боомтод ажиллаж байгаа улсын байцаагчид албан тушаалын үндсэн цалингийн 32 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдэл хөлсийг сар тутам олгох;

53.1.6.голомтын бүсэд ажилласан улсын байцаагчийн албан томилолтын зардлыг ердийн үеийнхээс гурав дахин нэмэгдүүлж олгох;

53.1.7.албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай хөдөлмөр хамгааллын хувцас, багаж, техник хэрэгслээр хангагдах.

53.2.Энэ хуулийн 53.1.2, 53.1.3, 53.1.5, 53.1.7-д заасан нэмэгдэл баталгаа хилийн боомтод ажиллаж байгаа мэргэжлийн хяналтын байгууллагын бусад албан хаагчид нэгэн адил үйлчилнэ.

53.3.Улсын байцаагч мэргэшлийн зэрэгтэй байх бөгөөд мэргэшлийн зэрэг тогтоох, зэргийн нэмэгдэл олгох журмыг Засгийн газар батална. Мэргэшлийн зэргийн нэмэгдлийг мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааны жил бүрийн төсөвт тусгана.

53.4.Улсын байцаагч цар тахал, хүний амь нас, эрүүл мэнд хохирох өндөр эрсдэлтэй нөхцөлд үүрэг гүйцэтгэвэл мөнгөн урамшуулал олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг санхүү, төсвийн болон мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

53.5.Орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагын улсын байцаагчийн албан тушаалын ангилал, зэрэглэл, цалин хөлс мэргэжлийн хяналтын төв байгууллагын улсын байцаагчтай ижил байна.

53.6.Мэргэжлийн хяналтын байгууллагын улсын байцаагч болон хилийн боомтод ажиллаж байгаа мэргэжлийн хяналтын байгууллагын бусад албан хаагч нь дүрэмт хувцас, ялгах тэмдэг хэрэглэнэ.

53.7.Энэ хуулийн 53.6-т заасан дүрэмт хувцас, ялгах тэмдгийн загвар, эдэлгээний хугацаа, хэрэглэх журмыг мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

53.8.Иргэн, төрийн байгууллага, албан тушаалтан, хэн боловч улсын байцаагчийн хууль ёсны үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, хуулиар хүлээлгэсэн чиг үүрэгт нь үл хамаарах ажил, үүрэг гүйцэтгэхийг шаардахыг хориглоно.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГААС ТӨРИЙН БУСАД
БАЙГУУЛЛАГАТАЙ ХАРИЛЦАХ

54 дүгээр зүйл. Мэргэжлийн хяналтын байгууллагаас Засгийн газартай харилцах

54.1.Мэргэжлийн хяналтын төв байгууллага хариуцсан чиглэлийн хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт, стантартын хэрэгжилтийн байдал, үр дүнгийн талаарх тайланг тухай бүр Засгийн газарт танилцуулна.

54.2.Засгийн газар мэргэжлийн хяналтын төв байгууллагын тайланг хуралдаанаар хэлэлцэж, мэргэжлийн хяналтын төв байгууллагаас гаргасан санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар Засгийн газрын тогтоол гаргана.

54.3.Засгийн газар мэргэжлийн хяналтын байгууллагад хуулиар хүлээлгэсэн чиг үүргийнх нь хүрээнд тодорхой салбар, чиглэлийн асуудлаар эсхүл төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд шалгалт хийлгүүлэхээр үүрэг, даалгавар өгч болно.

55 дугаар зүйл. Мэргэжлийн хяналтын байгууллагаас яам, агентлагтай харилцах

55.1.Мэргэжлийн хяналтын төв байгууллага болон яам, бусад агентлаг нь хамтран ажиллах, харилцан мэдээлэл солилцох, үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах, Захиргааны ерөнхий хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу харилцан туслах үүрэгтэй.

55.2.Мэргэжлийн хяналтын төв байгууллага нь үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцож, хамтран ажиллана.

55.3.Яам, агентлаг нь мэргэжлийн хяналтын төв байгууллагаас өгсөн санал, зөвлөмж, албан шаардлагын хариуг тогтоосон хугацаанд өгөх үүрэгтэй.

56 дугаар зүйл. Мэргэжлийн хяналтын байгууллагаас нутгийн захиргааны байгууллагатай харилцах

56.1.Мэргэжлийн хяналтын байгууллага Засаг даргатай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах асуудлаар хамтран ажиллах, үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулна.

56.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн нутаг дэвсгэрийн мэргэжлийн хяналтын байгууллагад хуулиар хүлээсэн чиг үүргийнх нь хүрээнд үүрэг даалгавар өгч болно.

56.3.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хурлаас гаргасан шийдвэрийн биелэлтийг хянан шалгахдаа тухайн шатны мэргэжлийн хяналтын байгууллагын туслалцааг авч болно.

56.4.Мэргэжлийн хяналтын байгууллага, улсын байцаагчийн үйл ажиллагаанд нутгийн захиргааны бүх байгууллага, албан тушаалтан туслах, шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж ажиллах үүрэгтэй.

56.5.Мэргэжлийн хяналтын байгууллагаас Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах асуудлаар санал, зөвлөмж өгч болно.

56.6.Нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтан нь мэргэжлийн хяналтын байгууллагаас өгсөн санал, албан шаардлага, зөвлөмжийн хариуг тогтоосон хугацаанд өгөх үүрэгтэй.

ДОЛООДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

57 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

57.1.Улсын байцаагчийн хууль ёсны шаардлага, хүчин төгөлдөр болсон шийдвэрийг биелүүлээгүй, эсэргүүцсэн, албан үүргээ гүйцэтгэхэд саад учруулсан, шалгалтаас зайлсхийсэн этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

57.2.Төрийн албан хаагч мэргэжлийн хяналтын байгууллагаас өгсөн санал, зөвлөмж, албан шаардлагын хариуг тогтоосон хугацаанд өгөөгүй, хуулиар хүлээсэн чиг үүргээ зорилгодоо нийцээгүй байдлаар хэтрүүлж хэрэгжүүлсэн, эсхүл чиг үүргээ хэрэгжүүлээгүй буюу дутуу хэрэгжүүлсэн, хуулийг тэгш бусаар, ялгавартайгаар хэрэгжүүлсэн нь тухайн төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

57.3.Энэ хуулийн 57.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд улсын ерөнхий байцаагч тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд улсын ерөнхий байцаагчид хариу мэдэгдэнэ.

57.4.Улсын байцаагч хуульд заасан үүрэг, шалгалт хийх журам, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн бол Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

58 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

58.1.Энэ хуулийг ___ оны __ дугаар сарын ___-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.